

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын  
Үзүүлэлтэд тулгуурласан навигацийн хэрэгжилт, зохицуулалтын ажлын хэсгийн 11 дүгээр  
хурал (Eleventh meeting of the performance based navigation implementation coordination  
group PBNICG/11)-д оролцсон тайлан

2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

## 1. Хурлын танилцуулга

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төвөөс зохион байгуулдаг Үзүүлэлтэд тулгуурласан навигацийн хэрэгжилт, зохицуулалтын ажлын хэсгийн хурал Тайландын Хаант улсын Бангкок хотод байрлах тус бүсийн төвийн хурлын танхимд 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 30-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан.

Тус хуралд Иргэний нисэхийн ерөнхий газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Агаарын навигацийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Х.Одхүү, Иргэний нисэхийн үндэсний төвийн Үйлдвэрлэл үйлчилгээний газрын ерөнхий менежер Э.Энхмөнх нар оролцсон.

Ажлын хэсгийн хурлаар Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд агаарын замын сүлжлийг хөгжүүлэх, агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, улс орнуудын уламжлалт навигаци бүхий агаарын зам, нислэгийн журмуудыг үзүүлэлтэд тулгуурласан агаарын зам, нислэгийн журмуудад шилжүүлэх хэрэгжилтийг дүгнэх, агаарын зайн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн сүүлийн үеийн техник технологийн шинэчлэлтүүдийн тухай авч хэлэлцсэн.

Ажлын хэсгийн хуралд Австрали, Бруней Даруссалам, Камбож, БНХАУ, Хонконг, Фижи, Энэтхэг, Индонези, Япон, Лаос, Малайз, Малдив, Монгол, Нипал, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Филиппин, БНАСАУ, Сингапур, Тайланд, АНУ, Вануату, Вьетнам улсууд, Олон улсын агаарын тээврийн байгууллага (IATA), Олон улсын нислэгийн журам зохиолт, шалгалтын холбоо (IFPDVA)-ны нийт 77 төлөөлөгч оролцсон.

- Ажлын хэсгийн хурлын даргаар Энэтхэг улсын Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигацийн үйлчилгээ хариуцсан захирал Р.С. Жамвал ажилласан.
- Ажлын хэсгийн хурлын нарийн бичгийн даргаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн мэргэжилтэн В.К Мишра ажилласан.

## 2. Хурлаар хэлэлцсэн асуудлууд


Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас гишүүн улсуудын дунд Хэрэглэлийн нислэгийн журмуудад хөндлөнгийн хяналт хийх тухай семинарыг 2024 оны 03 дугаар сарын 25-ний өдрөөс 26-ны өдрийн хооронд зохион байгуулсан.

Тус семинараар хэрэглэлийн нислэгийн журам зохиох, симулятор турших, нислэгээр шалган баталгаажуулах, нислэгийн зураг боловсруулах, нисэхийн мэдээллийн эмхэтгэлээр олон улсад зарлан мэдээлэх, үйл ажиллагаанд ашиглах хүртэлх бүхий л үйл ажиллагаанд байнгын хяналт явуулах, холбогдох материалуудыг тогтмол хадгалах, архивлах, гарсан алдаа дутагдлыг мэдээлэх, засаж залруулах тухай цогцолбор ойлголтыг оролцогчдод хүргэсэн.

Үзүүлэлтэд тулгуурласан навигацийн хэрэгжилт, зохицуулалтын ажлын хэсгийн хурал 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрөөс 29-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан.

Тус хурлаар дараах зүйлсийг хэлэлцүүлсэн. Үүнд:

- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн мэргэжилтэн В.К Мишра дэлхийн хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд гишүүн улсуудын үзүүлэлтэд тулгуурласан навигацийн хэрэгжилт ямар байгааг танилцуулсан.
- БНХАУ, Камбож, Энэтхэг, Индонези, Япон, Непал, Малайз, Папуа Шинэ Гвиней улсууд өөрсдийн улсад хийгдэж байгаа үзүүлэлтэд тулгуурласан навигацийн хэрэгжилтийг танилцуулсан.
- БНХАУ-ын зүгээс цэгт нэгтгэх ойртолтын удирдлагын үйлчилгээ сэдэвт нислэгийн хөдөлгөөний удирдлагын технологийг танилцуулсан.
- Австрали улсын зүгээс нислэгийн мэдээллийн район, нислэгийн хөдөлгөөний удирдлагын сектор солигдох үед нислэгийн хөдөлгөөний удирдлагын зайчлал бариулахад тулгарч буй асуудал сэдвээр танилцуулга хийсэн.
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн мэргэжилтэн В.К Мишра Дэлхийн навигацийн хиймэл дагуулын систем (GNSS)-ийн ICAO DOC 9849 баримт бичигт өөрчлөлт орж байгаа тухай танилцуулсан.
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн мэргэжилтэн В.К Мишра RNAV нислэгийн журмуудыг RNP нислэгийн журамд шилжүүлэх гөлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулсан.
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төв болон БНХАУ-ын Иргэний нисэхийн удирдах газар хамтран зохион байгуулдаг Нислэгийн журмын хөтөлбөр (FPP)-ын тухай ерөнхий зохицуулагч Еинг Лиу танилцуулсан.
- Хурлаар хэлэлцсэн асуудлууд, гарсан санал санаачилгуудыг эцэслэн баталж, дараагийн хурлын товыг хэлэлцэж, хурлын тайланд тусгахаар санал нэгдэж хурал өндөрлөсөн.



### 3. Гарсан үр дүн

1. Тус хуралд оролцсоноор Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төвөөс баримтлах бодлого чиглэлтэй танилцаж, үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн дэлхийн болоод бүс нутгийн хэрэгжилтийг үнэлж дүгнэн Монгол Улсын агаарын навигацгийн үйлчилгээний бодлого чиглэлд тусгах, үйл ажиллагааг олон улсын хэмжээнд нийцүүлэх мэдлэг мэдээллийг олж авсан.
2. Хэрэглэлийн нислэгийн журмуудад хөндлөнгийн хяналт хийх тухай мэдлэг, туршлагыг олж авсан.
3. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын үзүүлэлтэд тулгуурласан хэрэглэлийн нислэгийн журмын хэрэгжилтийн танилцуулгад Монгол Улсын RNAV нислэгийн журмуудыг RNP нислэгийн журамд шилжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн байсан. Монгол Улсын хувьд 2020 онд олон улсын нисэх буудлуудын 3 нислэгийн журмыг RNAV ангиллаас RNP болгох төлөвлөгөөг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-д хүргүүлсэн байсан бөгөөд хэрэгжилтийг мэдүүлээгүй байсан тул хангалтгүй үнэлэгдсэн байсан. Энэхүү үнэлгээг сайжруулахын тулд хийж хэрэгжүүлсэн нислэгийн журмуудыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-д хүргүүлэх, үнэлгээг өөрчлөх тухай хурлын нарийн бичгийн даргатай тохиролцсон.
4. Монгол Улсын үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэл дамжуулах ажилтны мэдээлэл шинэчлэгдээгүй байсныг шинэчлэхээр хурлын нарийн бичгийн даргатай тохиролцсон.
5. БНХАУ-ын Иргэний нисэхийн удирдах газрын харьяа Нислэгийн хөдөлгөөний менежментийн товчооны Агаарын зайн менежмент, нислэгийн журам боловсруулалтын төвийн дэд захирал Ван Рантай уулзаж Монгол Улс, БНХАУ-ын хооронд шинээр агаарын хаалга нээх сэдвээр уулзалт хийсэн. Уулзалтаар БНХАУ-ын тал шинээр агаарын хаалга нээх ажилд дэмжлэг үзүүлэн ажиллахаа илэрхийлсэн. Түүнчлэн Монгол Улсын зүгээс холбогдох хүсэлт, танилцуулгыг Хятад, Англи хэл дээр бэлтгэн Агаарын зайн менежмент, нислэгийн журам боловсруулалтын төвд хүргүүлэх ба БНХАУ-ын зүгээс холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж хамтран ажиллахаар харилцан тохиролцсон.
6. Нислэгийн журмын хөтөлбөр (FPP)-ын 2024 онд зохиогдох сургалт, семинаруудад Монгол Улсаас нислэгийн журам зохиогч мэргэжилтнүүдээ идэвхтэй оролцуулах хүсэлтээ ерөнхий зохицуулагч Еинг Лиутай уулзаж илэрхийлсэн.

## 10 Work Plan of 2024

| Date            | Activities                                   | Location*        | Participants | Strategic Objectives  | Organizer      |
|-----------------|--|------------------|--------------|-----------------------|----------------|
| 1 27-28 Feb     | PBN flight procedure design workshop for ATC | Online / Beijing | FPP and APAC | Expand Value Creation | FPP            |
| 2 15-17 Apr     | Procedure Design Refresher Course            | Online / Beijing | FPP and APAC | Expand Value Creation | FPP            |
| 3 21-24 May     | Charting-Coding workshop                     | Beijing/Online   | FPP and APAC | Expand Value Creation | FPP            |
| 4 17 Jun-12 Jul | Pans-Ops Procedure Design Initial Course     | Beijing/Online   | FPP and APAC | Expand Value Creation | FPP            |
| 5 09-27 Sep     | PBN Procedure Design Course                  | Bangkok / Online | FPP and APAC | Expand Value Creation | FPP/Host State |
| 6 11-15 Nov     | RNP-AR Workshop                              | TBD**            | FPP and APAC | Expand Value Creation | FPP            |

7. Ажлын хэсгийн хурлын үеэр төлөөлөгчидтэй Монгол Улсын агаарын зайд орсон өөрчлөлт, техник технологийн шинэчлэлт, агаарын замын сүлжил, агаарын навигацийн үйлчилгээний тухай танилцуулга уулзалтуудыг хийсэн.

ТАНИЛЦСАН:


БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН  
АГААРЫН НАВИГАЦИЙН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР



Ч.ОДГЭРЭЛ

Б.БАТБАЯР



Х.ОДХҮҮ

Э.ЭНХМӨНХ.

Э.ЭНХМӨНХ